ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2026 оны 10 дугаар сарын 16-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-7

1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайлан 3-7

Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
10 дугаар сарын 16-ны өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл

Хууль зүйн байнгын хорооны дарга Л.Мөнхбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 28 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 60.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 31 минутад Төрийн ордны "Их засаг" танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баасанжаргал, Х.Баттулга, Г.Дамдинням;
Тасалсан: Н.Алтанхуяг, Б.Дэлгэрсайхан, Д.Цогтбаатар.

Нэг.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч Г.Эрдэнэбулган, Б.Амартүвшин, Ч.Отгонсүрэн, Б.Даваажав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хорооны асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайланг сонсгол даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нууц санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 1
Бүгд: 20
95.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэр дэвшигчийг томилох саналыг нууц санал хураалтаар явуулав.

Л.Мөнхбаатар: Ганзоригийн Эрдэнэбулганыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 11
Бүгд: 22
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Батчулууны Амартүвшинг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 2
Бүгд: 22
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Чимэдийн Отгонсүрэнг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 22
Бүгд: 22
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Базаррагчаагийн Даваажавыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 09 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.
Хуралдаан 22 минут үргэлжилж, 28 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 78.6 хувийн ирцтэйгээр 09 цаг 53 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА Л.МӨНХБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 10 дугаар сарын 16-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
09 цаг 31 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Мөнхбаатар: Гишүүд хурлаа эхэлье. Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амрыг эрье. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2026 оны 10 дугаар сарын 16-ны хуралдаан нээснийг мэдэгдье.

Ирц танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэл, Лхагвын Мөнхбаатар, Даваахүүгийн Пүрэвдаваа, Цэндийн Сандаг-Очир, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Саруулсайханы Цэнгүүн, Энхбаярын Батшугар, Одсүрэнгийн Номинчимэг, Бөхчулууны Пүрэвдорж, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Гончигдоржийн Уянгахишиг, Сүхбаатарын Эрдэнэболд, Баярмагнайн Баярбаатар, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг, Салдангийн Одонтуяа. Өөр хэн орсон байна. Соронзонболд гишүүн, Эрдэнэболд гишүүн, Уянгахишиг нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр нэг асуудал хэлэлцэнэ.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэх сонсголын тайланг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэх санал дэвшүүлэх санал, сонсголын тайланг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсэг орох болсон уу, үгүй юу? Танилцсаны дараа юу?

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 95, 96 дугаар тогтоолоор томилогдсон Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу Хууль зүйн байнгын хорооноос Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг 2026 оны 05 дугаар сард зохион байгуулсан.

Ажлын хэсэг сонгон шалгаруулалтыг хууль, журмын хүрээнд зохион байгуулж, нэр дэвшигчдийг Хууль зүйн байнгын хороонд санал болгосны дагуу Хууль зүйн байнгын хороо нэр дэвшигчийн сонсголыг 2026 оны 10 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан.

Уг сонсголын тайланг сонсгол даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг танилцуулна. Уянгахишиг гишүүнд микрофон өгье. Уянгахишиг гишүүний микрофон өгөөрэй.

Г.Уянгахишиг: Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч Г.Эрдэнэбулган, Б.Амартүвшин, Ч.Отгонсүрэн, Б.Даваажав нартай хийсэн нэр дэвшигчийн сонсголын тайланг танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатаар ахлуулсан ажлын хэсэг хууль, журамд заасан Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, олонхын санал авсан дээрх 4 нэр дэвшигчийг Хууль зүйн байнгын хороонд санал болгосон.

Байнгын хорооны 2026 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 20 дугаар тогтоолын дагуу сонсголыг 2026 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд зохион байгууллаа.

Сонсголыг миний бие даргалж, Хууль зүйн байнгын хорооны 20 гишүүн болон ажиглагчаар 1, оролцогчоор 6 иргэдийн төлөөлөл оролцлоо.

Сонсголоор ажлын хэсгийн тайланг сонсож, нэр дэвшигчид өөрсдийн боловсрол, мэргэжил, ажлын туршлага, нэр дэвших болсон үндэслэл болон томилогдвол хийх ажлын талаар танилцуулсан болно.

Тухайлбал, нэр дэвшигч Г.Эрдэнэбулган шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх, шүүхийн ачааллыг тэнцвэржүүлэх, хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, үйлчилгээний чанар, нээлттэй байдлыг сайжруулахад анхаарахаа илэрхийлсэн.

Нэр дэвшигч Б.Амартүвшин шүүхийн хүний нөөц, төсөв, санхүүгийн баталгааг сайжруулах, захиргааны үйл ажиллагааг зохисгүй нөлөөллөөс хамгаалах, цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр төлөвлөснөө танилцуулсан.

Нэр дэвшигч Ч.Отгонсүрэн эдийн засаг, санхүүгийн мэдлэг, туршлагадаа тулгуурлан шүүхийн төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг боловсронгуй болгох, санхүүгийн баталгааг бэхжүүлэхэд ажиллахаа илэрхийлсэн.

Нэр дэвшигч Б.Даваажав шүүгчийн сонгон шалгаруулалтыг мэргэшилд суурилсан, ил тод, тэгш боломжтой болгох, шүүхийн дэд бүтэц, аюулгүй байдлыг сайжруулах, иргэн төвтэй цахим үйлчилгээг хөгжүүлэхээр төлөвлөснөө танилцуулсан.

Гишүүд болон оролцогчид нэр дэвшигчдийн мэргэшил, туршлага, ёс зүй, ашиг сонирхлын зөрчил, улс төрийн нөлөөллөөс ангид ажиллах чадвар, хэрэгжүүлэх ажлын бодит төлөвлөгөөний талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Хуульд заасан журмын дагуу сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч тус бүрээр тухайн албан тушаалд тавигдах шаардлага хангасан эсэх талаар санал хураалт явуулсан бөгөөд хуралдаанд оролцсон нийт 14 гишүүнээс

нэр дэвшигч Б.Амартүвшинийг 9 гишүүн буюу 64.29 хувь, нэр дэвшигч Б.Даваажавыг 7 гишүүн буюу 50 хувь, нэр дэвшигч Г.Эрдэнэбулганыг 4 гишүүн буюу 28.57 хувь, нэр дэвшигч Ч.Отгонсүрэн 2 гишүүн буюу 14.29 хувь нь тус тус шаардлага хангасан гэж үзсэн бөгөөд дүгнэлтийг сонсголын тайланд тусган та бүхэнд тараасан болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Мөнхбаатар: Уянгахишиг гишүүнд баярлалаа. Хуралдаанд оролцож байгаа нэр дэвшигчдийг танилцуулъя. Нэр дэвшигч Ганзоригийн Эрдэнэбулган, Батчулууны Амартүвшин, Чимэдийн Отгонсүрэн, Базаррагчаагийн Даваажав нар оролцож байна.

Сонсголын тайлан болон нэр дэвшигчдийг танилцуулж дууслаа. Одоо сонсголын тайлантай холбогдуулан, мөн нэр дэвшигчдээс асуулт асуух гишүүн байвал нэрсээ өгье.

Байхгүй байна.

Сонсголын тайлантай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу?

Байхгүй байна. Одоо та бүгдэд санал хураалт явуулна. Та бүгдэд бас дэгийн хуулийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.4 дэх хэсэгт Хууль зүйн байнгын хороо хуульд заасны дагуу санал болгосон нэр дэвшигч нэг бүрээр санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар нэр дэвшүүлэхийг дэмжсэнд тооцно гэж заасны дагуу санал хураалтыг явуулъя.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэнэ шүү. Горимын санал байгаа юм уу? Баярбаатар гишүүн горимын санал гаргаж байгаа юм байна. Баярбаатар даргын микрофоныг.

Б.Баярбаатар: Байнгын хорооны гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Нэр дэвшигчдэдээ бас амжилт хүсье. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн сонгон шалгаруулах хариуцлагатай сонголтыг хийх гэж байна. 4 жилийн хугацаатайгаар сонгогдоно. Байнгын хорооны гишүүд санал хураалтыг дэгийн хуулийн 10.1-д заасны дагуу нууц санал хураалтаар асуудал нэг бүрчлэн санал хураалтыг явуулахыг горимын саналыг гаргаж байна. Дэмжиж өгөхийг хүсье.

Г.Мөнхбаатар: Баярбаатар гишүүн санал хураалтыг юу яая гэж байгаа юм байна тээ, нууц санал хураалтаар явуулъя гэсэн горимын санал гаргаж байгаа юм байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.1-д хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлыг ил санал хураалтаар шийдвэрлэнэ.

Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хууль, бусад хуульд заасан, эсхүл хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар нууц санал хураалт явуулж болно гэж заасан.

Тэгэхээр Баярбаатар гишүүний саналыг олонх дэмжих юм бол санал хураалт нууц болно гэсэн үг шүү. Баярбаатар гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Бүгдээрээ бэлдье. Энэ бол горимын тухай санал. Үүгээрээ өгнө. Энэ болохоороо нууц санал хураалт явуулах уу, үгүй юү гэдэг талаар санал хураалт явуулах гэж байна шүү дээ. Баярбаатар гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье. Гишүүд, гишүүд анхааралтай.

Улсын Их Хурлын гишүүн Баярбаатарын гаргасан горимын саналаар уг санал хураалтыг нууцаар буюу 10.1-д заасан журмаар явуулахаар гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 95 хувь нь дэмжсэн байна. Уг санал хураалтыг дэгийн хуульд заасны дагуу 11-д заасан журмаар явуулна. Бэлтгэлийг манай Байнгын хорооны ажилтнууд бэлтгэл хангая.

Гишүүд ээ санал хураахад техникийн хувьд боломжтой байгаа биз, болсон уу? Байнгын хорооныхон бэлтгэл хангасан байна. Гишүүд анхааралтай. Санал хураалтыг эхлүүлье. Санал хураалтад бэлтгэе. Гишүүд санал хураалт. Отгонбаяр гишүүн. Гишүүд бэлдсэн байна. Гишүүд анхааралтай. Та нар чинь анх удаагаа ямар санал өгч үзэж байгаа биш дээ энэ чинь. Дахиад яриадах юм. Санал хураалт явуулъя.

Нэр дэвшигч Ганзоригийн Эрдэнэбулганыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 11 нь буюу 50 хувь нь дэмжсэн байна. Уг санал дэмжигдсэнгүй. Санал хураалтад оролцсон гишүүдийн 11 нь буюу 50 хувь нь дэмжсэн байна. Уг санал дэмжигдсэнгүй. Дэмжигдсэнгүй.

2.Батчулууны Амартүвшинийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 20 нь буюу 90.9 хувь нь дэмжигдсэн байна. Дэмжигдлээ.

3.Чимэдийн Отгонсүрэнг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 22 нь дэмжээгүй буюу хүн дэмжээгүй байна. Санал, уг санал дэмжигдсэнгүй.

Гишүүд анхааралтай, гишүүд анхааралтай. Дараагийн санал хураалтыг явуулъя.

Базаррагчаагийн Даваажавыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 13 нь буюу 59.1 хувь нь дэмжсэн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан дууссаныг мэдэгдье.

09.53 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР